

Зөвшөөрлийн нэгдсэн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Ядам Хулан

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;							
1	Эдийн засгийн салбарын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, эрх зүйн орчныг шинэчлэх талаар судалж, сайжруулах арга хэмжээний төсөл бэлтгэнэ.	Хуулийн төсөл боловсруулсан байх	-	-	Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн 2025 оны А/31 дугаар тушаалаар "Даатгалын системийг үнэлж, төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх хууль эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах" хамтарсан ажлын хэсгийг дотоод газар нэгжүүдээс нэр авч байгуулсан бөгөөд эдийн засгийн бүтэц, төрийн болон төсвийн зардлыг багасгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын хэсгийг байгуулсан. Эдийн засгийн салбарын бүтцийн өөрчлөлт,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, эрх зүйн орчныг шинэчлэх талаар судалж, сайжруулах арга хэмжээний төслийг сүүлийн хагас жилд тайлагнах тул ажлын хэсэг гишүүд төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
2	Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувиар	-	Хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. /5 хувь/	Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, экспорт импортыг нэмэгдүүлэх, хил дамнасан худалдааг хөнгөвчлөх зорилго бүхий "Хил дамнасан цаасгүй худалдааны үндэсний зөвлөл"-ийн ажлын хэсэгт Монгол Улсын гадаад харилцааны сайдын 2025 оны А/02 дугаар тушаалаар орж ажиллаж, Монгол Улсын худалдааны гарц бүхий "Замын-Үүд" боомтод 2025 оны 04 дүгээр сарын 15-19 - ны өдрүүдэд ажиллав. Тус томилолтоор боомтын үйл ажиллагаатай танилцан, БНХАУ-ын Эрээн боомт, Хөх-Хотын гаалийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, 2 талын худалдаа, бүртгэл, гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөхөд чиглэсэн тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн шат дараалсан зохих арга	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хэмжээг авч ажиллах төлөвлөгөөг гарган ажиллав. Энэхүү томилолтын хүрээнд бизнес эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж худалдаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн зохих арга хэмжээг авч ажиллах төлөвлөгөөг ажлын хэсгээр хэлэлцүүлэн батлуулж ажиллав. Мөн хэрэглээний гол нэрийн барааны үнэ бүрдэлт, үнийн хэт хөөрөгдөлтийг судлан Монгол Улсын шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдад танилцуулж шат дараалсан ажлын төлөвлөгөө, чиглэлийг танилцуулав. Хавсралт: 1 файл		
3	"Нийгмийн хариуцлагын ISO 26000" стандартыг нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангана.	Мэдээлэл сурталчилгаанд хамрагдах аж ахуйн нэгжийн тооны өсөлт, хувиар	-	Стандартыг нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангасан байна. /5 хувь/	Нийгмийн хариуцлагын ISO260000 стандарт болон бусад стандартыг хэрэгжүүлэх, сурталчлах, олон нийтэд таниулах зорилго бүхий "Нэг улс, Нэг стандарт" ажлын хэсэгт орж ажиллан, ажлын төлөвлөгөө гаргах, зорилтод бүлэг, стандартын хэрэгжилтийг дүгнэх чиглэлээр судалгаа хийн ажиллаж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
1.2. Салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийх, бизнесийн орчныг дэмжих, учирч буй хүндрэлийг бууруулах, өмчийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого зохицуулалт хийх, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах,							

тэдний санал гомдлыг хүлээн авах мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, холбогдох төрийн байгууллагуудад санал боловсруулах, жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих, бойжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн олон талт, бодитой арга хэмжээг хэрэгжүүлэх;

4	Бизнесийн орчныг дэмжих бодлого тодорхойлох хүрээнд холбогдох байгууллагатай хамтран танилцуулга бэлтгэх, хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байх	-	-	1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна. УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2-т заасан “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” зорилтын 3.2.2.4-т “Төрийн байгууллагаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж, 4.2.2-т “Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал” зорилтын 4.2.2.5-д “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулах төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна.” гэж тус тус заасан байдаг. Зөвшөөрлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	--	---	---	--	---	------

					тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан зөвшөөрөл олголтын процессыг хөнгөвчлөх хүрээнд олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан, гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзэхэд тусгай болон энгийн зөвшөөрлөөс гадна зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэх замаар тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай байна. Дээрх хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан нийт 85 хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна. 2. МУЗГ 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Төрөөс шинээр зохицуулалт, зөвшөөрөл нэвтрүүлэхтэй холбогдуулан нийгэм эдийн засгийн үр нөлөө, эрх зүйн орчны хяналт шинжилгээ үнэлгээ хийх судалгаа"-ны ажлыг шууд гэрээ байгуулан	
--	--	--	--	--	--	--

					гүйцэтгүүлсэн бөгөөд аргачлалын төслийг боловсруулан дотоод газруудаас санал авч, 2025.05.01-ний 01/1156 тоот албан бичгээр засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлж, холбогдох саналыг тусгаж ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэл ажлын ханган ажиллаж байна. Хавсралт: 3 файл		
5	Бизнес эрхлэх орчны үнэлгээ хийх, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Танилцуулгын тоо	Суурь судалгаа хийгдсэн	Арга хэмжээний танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	1. Бизнес эрхлэх орчны үнэлгээ хийх, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЭЗХСайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан улсын болон урсгал төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан ЭЗХЯ/20250203089 дугаартай "Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, шинээр батлуулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх судалгаа"-ны ажлын даалгавар, тендер шалгаруулах үнэлгээний хороо, ТШББ-ыг боловсруулан 2025.05.20-ны өдөр тендерийг зарлаж, 2025.05.28-ны өдөр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					тендерийг амжилттай нээж, хамгийн сайн үнэлэгдсэн компанийг шалгаруулан тендерийн гэрээг байгуулахаар ажиллаж байна. 2. Бизнес эрхлэх орчны үнэлгээ хийх, салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЭЗХСайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан улсын болон урсгал төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан ЭЗХЯ/20250203076 дугаартай "Хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгчдийг дэмжих эрх зүйн орчны шинэчлэлийн төлөөр хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцооны судалгааг хийх" худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлын даалгаврыг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулахаар хүргүүлсэн. 3. Олон улсын Санхүүгийн байгууллага, Дэлхийн банкт хамтран "BE-READY" бизнес эрхлэх орчны үнэлгээг хийх шинэ аргачлалд тулгуурласан судалгааг Монгол Улсын хэмжээнд хийхэд хамтран ажиллаж байна. 4. ГХЯ-тай		
--	--	--	--	--	--	--	--

					хамтран зохион байгуулсан "Хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийн гишүүдийг хил дамнасан худалдааны үйл явц, саад бэрхшээлийг судлах, гааль, тээвэр, логистикийн байгууллагуудтай холбогдох уулзалтуудыг хийлгэж, санал солилцуулах зорилгоор 4 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд ажиллаж, Замын-Үүд боомт, БНХАУ-ын Эрээн боомтын үйл ажиллагаатай танилцан, гаалийн бүрдүүлэлтийн агентууд, тээвэрлэгч болон бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг судлав. Хавсралт: 3 файл		
6	Зөвшөөрөл олгох эрх шилжүүлэх, гэрээ байгуулах журмын төсөл, засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар батлуулна.	Засгийн газрын хуралдаанаар батлуулах баримт бичгийн тоо	-	Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт батлуулсан байна. /1 акт/	Монгол Улсын Засгийн газрын 2024-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу БНКУ-ын Зохицуулалт нөлөөллийн шинжилгээний журмын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					үндэслэн "Зөвшөөрөл олгох эрх шилжүүлэх журам"-ын төслийг боловсруулан 2025 оны 01/71 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн засаг дарга нараас санал авч, 2025.02.10-ний Монгол улсын Засгийн газрын хуралдаад хэлэлцүүлэхээр 01/386 тоот албан бичгээр хүргүүлж, 2025.02.26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хавсралт: 3 файл		
7	Зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалтад уялдуулан кодлох баримт бичгийг боловсруулна.	Боловсруулах баримт бичгийн тоо	-	Төсөл боловсруулсан байна. /1 төсөл/	Зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалтад уялдуулан кодлох баримт бичгийн хүрээнд Үндэсний статистикийн хороонд 2025.01.07-ны 03/35 албан тоот хүргүүлж, уулзалтыг 2025.02.27-нд Үндэсний статистикийн хорооны Нямдаваа /ангилал хариуцсан ахлах/, Нямбаяр /ахлах статистикч/, Амаржаргал /бизнес бүртгэлийн ахлах/ нартай уулзсан. Тус уулзалтаар Зөвшөөрлийн тухай хуулийн хүрээнд олгож байгаа энгийн болон тусгай зөвшөөрлийг ангилахад зарим нэг ангилал тусаагүй байх, нэршил өөр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					байх зэрэг хүндрэл үүсэж, мөн цаашид шинээр бий болсон тохиолдолд хэрхэн кодлох талаар санал солилцсон. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллыг 2025 онд шинэчлэх бөгөөд ойролцоогоор 52% нь өөрчлөгдөн батлагдах, мөн зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор тус ажлыг 2025 оны сүүлийн хагаст жилд хийхээр ҮСХороо, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөллүүдийг оролцуулан хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллахаар болсон. Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зөвшөөрлийг тусгай, энгийн, мэдэгдлийн шинж чанартай гэсэн 3 төрлөөр олгохоор хуулийн зохицуулалт хийж байгаа тул зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2, 8.3 дахь зөвшөөрлийн жагсаалтыг дахин кодлох шаардлага давхар үүсэж байна. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллыг Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргатай хамтран		
--	--	--	--	--	---	--	--

					батлуулна. Хавсралт: 3 файл		
8	Шуурхай мэдээлэл бэлтгэх, зөвшөөрлийн мэдээллийн санг тухай бүр үүсгэж, удирдлагыг шуурхай мэдээллээр хангана.	Мэдээллийн тоо	-	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нэгдсэн сан /license.mn/-г хөгжүүлэн, 2025 оны бдугаар сарын байдлаар эрх бүхий байгууллагаас олгож байгаа 60 зөвшөөрлийг хүсэлт хүлээн авахаас олгох хүртэлх бүх үйл ажиллагааг цахим хэлбэрээр бүрэн шийдвэрлэж байна. Зөвшөөрлийн нэгдсэн санд эрх бүхий 32 байгууллагын 303 албан хаагчид мэдээлэл оруулах эрхийг нээсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын байдлаар 175'155 зөвшөөрлийн мэдээлэл бүртгээд байна. ЗГХЭГ-ын даргын 2025 оны 34 дүгээр тушаалаар байгуулагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус газраас төрийн холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлж зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг шууд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				хариуцан ажилладаг албан хаагчтай уулзах уулзалтыг зохион байгуулж нийт 14 эрх бүхий байгууллагын 114 албан хаагчтай уулзалт зохион байгуулж ажлын хэсэгт уулзалтын тайланг дүгнэлтийг танилцуулсан. МУЗГ-ын 7 дугаар тэмдэглэлийн хүрээнд БХБОСЯ-ны харьяа Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ, Цагдаагийн ерөнхий газраас олгож байгаа зөвшөөрлийн хөгжүүлэлт, Нийслэлийн эрүүл мэндийн газраас зөвшөөрлийг license.mn-ээр шийдвэрлэхтэй холбоотой заавар зөвлөгөө өгч, ЦХИХХЯ-наас олгож байгаа 2 энгийн зөвшөөрлийн хөгжүүлэлт, ОБЕГ-аас олгодог зөвшөөрлийн хөгжүүлэлтийг эхлэхтэй холбоотойгоор уулзалтыг зохион байгуулаад байна. Зөвшөөрлийн цахим системийн админ эрхийг яам тус бүр дээр гаргаж өгөхтэй холбоотой админ эрх салгах хөгжүүлэлтүүд болон бусад сайжруулалтууд, админ эрхээс толгой байгууллага бүртгэх хөгжүүлэлт, гарсан хүсэлтийн хуваарилалтыг өмнөх албан хаагчид буцаах цонхны хөгжүүлэлтүүд хийж, ЭЗХЯ-ны зөвшөөрөл	
--	--	--	--	---	--

					хариуцсан мэргэжилтэнд эрхийг тохиргоо хийх, админ эрхийн сургалтыг ГТСМТТ-өөс зохион байгуулсан болно. Хавсралт: 4 файл		
9	Салбарын шинэчлэлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	Мэдээллийн тоо	-	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Салбаруудын шинэчлэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтийн сүлжээ дахь яамны албан ёсны хуудас, тухайн зохион байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааны тайланд тусгах замаар сурталчлан танилцуулав. Үүнд: 1. Дэлхийн банк, ОУ-ын санхүүгийн байгууллагатай хамтран BE-RAEDY бизнес эрхлэх орчны үнэлэх шинэ аргачлал дээр тулгуурласан судалгааны ажилд хамтран ажиллах болсон тухай: 2. Монгол Улс-БНСУ-ын эдийн засгийн түншлэлийн гэрээтэй холбоотой олон нийтийн хэлэлцүүлэг 3. ГХЯ-тай хамтран зохион байгуулсан Цаасгүй худалдаа ажлын хэсгийн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлэг, сургалт семинарын талаарх мэдээ мэдээлэл: Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ


№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинарт оролцсон байх.	Сургалт, семинарт оролцсон байх.	-	Сургалт, семинарт оролцсон байна	1. Зөвшөөрлийн цахим систем /license.mn/-ийн админ эрх олгох, системийн тохиргоог хийх, зөвшөөрлийн тохиргоог холбох, бүртгэх талаарх мэдээлэл олгох онлайн сургалтад 2025.05.22-ны өдөр хамрагдав. 2. ХОНБЗГ-аас 2025.05.22-ны өдөр зохион байгуулсан "Ногоон төслүүдийн бэлэн байдлыг хангах нь" сэдэвт сургалтад хамрагдав. 3. Дэлхийн банкнаас зохион байгуулсан "Монгол Улсад хил дамнасан малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд вакцины нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд хийгдэх ажлын тайлангийн хуралд хамрагдав.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Яамнаас зохион байгуулагдсан мэдээллийн цагт тогтмол оролцсон байх	Мэдээллийн цагт оролцсон байх.	-	Мэдээллийн цагт оролцсон байна.	Яамнаас зохион байгуулагдсан мэдээллийн цагт тухай бүр оролцож байсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАНИЛЦСАН:

Салбарын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газрын Салбарын шинэчлэл,
бизнесийн орчныг дэмжих хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Золзаяа /



ТАЙЛАН ГАРГАСАН:

Зөвшөөрлийн нэгдсэн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Ядам Хулан /

J. Хулан

Огноо:

2025.06.25